

Эрт үед Галилын нутаг дэвсгэрт байдаг Кана хэмээх тосгонд хуримын найр болж байлаа.

Тэр хуримд Есүс болон Түүний шавь нар мөн эх Мариагийн хамтаар уригдав.

Хуриманд уригдсан зочид нь амтат хоолоор дайлуулж, ууцгаан хөгжилтэй цагийг өнгөрөөж байв.

Бүгд цагийг сайхан өнгөрөөж байх яг тэр үед! Гэнэт нэгэн зарц яаран гүйж ирээд найрын ахлагчид ингэж хэлэв.

“Бидэнд асуудал үүслээ! Усан үзмийн дарс бүгд дуусчихлаа! Бидний бодсоноос ч илүү их зочид хүрэлцэн ирсэн бололтой. Одоо бидэнд дусал ч дарс үлдсэнгүй.” гэв. Найрын ахлагч яах учраа олохгүй байх үед Есүсийн эх Мариа усан үзмийн дарс дууссан гэх мэдээг сонслоо. Тэгээд Мариа Есүсийг хайж эхлэв.

Учир нь Мариа, энэ асуудалд Есүс тусалж чадна гэдэгт итгэж байв. Тиймээс ч Мариа зарц нарт “Есүсийн айлдсаны дагуу хийгээрэй” гэж хэлэв. Есүс болон зарц нар хамтдаа хуримын найр болж байгаа газар руу ойртон очив.

Тэнд чулуун торх зургаан ширхэг байлаа.

Тэр чулуун торхнуудыг юунд ашигладаг байсан бэ гэвэл гадагшаа гараад буцаад ирэхдээ гараа угаах ус юм уу эсвэл аяга тавгаа угаах усыг хадгалдаг савнууд байлаа.

Есүс зарц нарт ингэж айлдав. “Торхнуудыг усаар дүүргэ” гэв. Зарц нар Түүний хэлсний учрыг ерөөсөө ойлгохгүй байв.

Гэхдээ Есүсийн айлдсанчлан торхнуудыг усаар дүүргэж эхлэв.

Харин зарц нар найрын ахлагчид усан үзмийн дарс аваачиж өгөв.

Зарц нарын авчирсан усан үзмийн дарсыг найрын ахлагч амсах мөчид түүний царай баясгалантай болов.

Тэр усан үзмийн дарсыг хаанаас бий болсныг мэдэхгүй ч сэтгэл нь хөөрч сүйт залуу руу яаран гүйв.

Тэгээд тэрээр ингэж хэлэв.

“Аливаа хүн эхлээд сайн дарсаа гаргаад, хүмүүсийг согтсоны дараа муухнаа гаргадаг.



Гэтэл чи эхэнд ч тэр төгсгөлд ч тэр сайн дарсаа гаргаж өгч байна. Үнэхээр гайхалтай.”

Тэр өдөр хуримын найран дээр ирсэн бүх зочид Есүсийн усаар хийсэн хамгийн сайн дарсыг ууж, хуримын найр дуустал цагийг сайхан өнгөрүүлэв.



Доорх зургийг өнгөөр ялгаж будаарай. Хайчилбарын дагуу хайчлаарай. Жишээ зурагт үзүүлсэн шиг цаасан бэхэлгээг ашиглан бэхлээрэй.

Дугуй дүрсийн талыг нь улаан
өнгөөр, нөгөө талыг нь цэнхэр
өнгөөр будаарай.



- Дараах библийн эшлэлийг дуурайж
бицээд цээжлээрэй.. (Иохан 2:5)

Тэр та нарт юу айлдана,
түүнийг үйлд гэв.

Жишээ зураг



Материал:

Хайч, Өнгийн харандаа, Цаас тогтоогч

Бүтээлч байцгаал 2. Өнөөдөр юу сурснаа сайн бодонгоо өнгөөр ялгаж будаарай.

